



2007 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн хөдөлмөрийн биржид иргэдээс ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг мэргэжилтнүүдэд танилцуулан мөрдөн ажиллахыг Нийслэлийн хөдөлмөрийн биржийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн /Б.Халиун/-д үүрэг болгосугай.



Б.БАТБААТАР

Нийслэлийн Хөдөлмөрийн биржийн захирлын 2007 оны.....<sup>09</sup> сарын.....<sup>06</sup> ны өдрийн УХА-0407.....<sup>11.2007</sup> тушаалын хавсралт

## ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Энэ журмын зорилго нь “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, болон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг үндэслэл болгоно.

### Нэг. Өргөдөл гомдол гаргах

Иргэд өргөдөл, гомдол гаргахдаа хуульд нийцүүлэн бичгээр буюу амаар биечлэн гаргана.

Өргөдлийг тухайн асуудлыг шууд хариуцан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд, гомдлыг тухайн асуудалтай холбогдож байгаа албан тушаалтныг шууд харьяалсан удирдах албан тушаалтанд гаргана

Өргөдөл гомдол гаргагч нь эрхэлсэн ажил, албан тушаал, нэр, гэрийн хаяг, өргөдөл бичсэн он сар өдөр зэргийг үнэн зөв бичиж гарын үсэг зурсан байна.

### Хоёр. Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх

1.Иргэдээс амаар буюу бичгээр болон цахим сүлжээгээр ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авна.

а/ Бичгээр ирсэн өргөдөл гомдлыг бичиг хэргийн ажилтан хүлээн авч дэвтэрт бүртгэн хяналтын карт нээж холбогдох албан тушаалтанд өгнө.

б/ “Нууц”, “Гарт нь” гэж хаягласан өргөдөл гомдлыг тухайн нэр заагдаж ирсэн албан тушаалтанд шууд өгнө. Хүлээн авсан албан тушаалтан өдөртөө багтаан бичиг хэргийн эрхлэгчид заавал бүртгүүлнэ.

в/ Амаар биечлэн гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч байгаа албан тушаалтан тусгай дэвтэрт тэмдэглэн авч өргөдөл гомдол гаргагчаар гарын үсэг зуруулна.

г/ Биржийн захирал Өргөдөл гомдол хүлээн авах өдөр цагийн хуваарийг тогтоон мөрдүүлнэ.

### Гурав. Иргэдийн санал өргөдөл гомдлыг хянах, шилжүүлэх, буцаах

1.Иргэдийн өргөдөл гомдол бүрийг үнэн зөв шийдвэрлэхийн тулд тавьсан асуудлыг судлан үзэж тухайн байгууллагын эрх хэмжээнд хамаарагдах эсэхийг тогтооно.

2. Байгууллагын эрх хэмжээнд хамаарахгүй өргөдөл гомдлыг харьяалах газарт нь 3 хоногийн дотор шилжүүлж өргөдөл гаргагчид энэ тухай бичгээр буюу амаар заавал мэдэгдэнэ.

3. Өргөдөл гомдол гаргагчаас тодруулах боломжтой баримт сэлтийг шаардан авч болно.

4. Дараах үндэслэлээр өргөдөл гомдлыг хянан үзэхгүй байж болно.

а/ Өргөдөл гомдол нь тодорхой нэр хаяггүй байх.

б/ 16 насанд хүрээгүй хүүхэд буюу шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг эх асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол.

в/ Өргөдөл гомдол нь тодорхой нэр хаяггүй бол хүлээж авахгүй.

### **Дөрөв. Өргөдөл гомдлыг шийдвэрлэж, хариу өгөх хяналт тавих**

1. Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана.

2. Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэж бичгээр хариуг өгнө.

3. Өргөдөл гомдлын хариуг амаар буюу утсаар мэдэгдсэн бол бүртгэлд тэмдэглэл хийнэ.

4. Өргөдөл гомдлыг хүлээн авч бичиг хэрэгт албан ёсоор бүртгэсэн өдрөөс эхлэн дараах хугацаанд хянаж шийдвэрлэн хариу өгнө.

а/Шалгаж судлах шаардлагагүй өргөдөл гомдлыг 7 хоногийн дотор

б/Шалгаж судлах зайлшгүй шаардлагатай өргөдөл гомдлыг 30 хоногийн дотор

в/Өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэхэд шалгалт судалгаа хийх, баримт материал гаргуулах зэрэг нэмэлт ажиллагааны улмаас хугацаандаа багтааж шийдвэрлэж чадахгүй бол биржийн захирлын шийдвэрээр хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болох ба энэ тухай өргөдөл гомдол гаргагчид мэдэгдэнэ.

г/ Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.

### **Тав. Өргөдөл гомдлын тайлан мэдээ гаргах**

Өргөдөл гомдлын мэдээ тайланг хагас бүтэн жилээр гаргана.

-----oO-----